



М.Есөнмөнх

Монголын Хүүхэд Залуучуудын Хөгжлийн
Төвийн Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал

СОРГОГООР ХАРЖ, СЭРГЭГЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ, УХААНТАЙ АЖИЛЛАЦГААЯ

Анх Москва хотноо сургууль төгсч ирчихээд, хэсэг нөхдийнхөө хамт өнчин, ядуу хүүхдүүдэд туслах үйлс сэдэж, бага боловч зоримог үйл ажиллагаа эрхэлж байсан бол нэг л мэдэхэд эрхэлж буй ажил үйлс маань цар хүрээгээ тэлж, нэгдсэн зохион байгуулалт, гүйцэтгэх ажлын албатай болох шаардлага урган гарч ирснээр, 1997 онд Монголын Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төв ТББ-ыг байгуулж байлаа. Тэр цагаас хойш хийж бүтээсэн ажил болгон минь амьжиргааны доод түвшний болоод энгийн бусад өрхийн хүүхэд, өсвөр үе, залуучуудад хүрч, үр дүнгээ ч бодитой харуулж байгаа маань олонд мэдрэгдэх бүрийд бид урамшиж байдаг юм. Анх байгуулагдаад үйл ажиллагаагаа явуулж байсан тэр 97 оныг эргээд санахад урам зориг мохоох олон л зүйлс тохиолддог байж. Үйл ажиллагаагаа явуулах өөрийн гэсэн ажлын байргүй, ямарваа хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулах гэхэд хөрөнгө мөнгөний гачаал тулгарах зэрэг бусад Төрийн бус байгууллагынханд учирдаг хүндрэл, бэрхшээл биднийг бас тойроогүй. Гэвч бид үйл ажиллагаагаа тасалдуулалгүй явсаар 2004 онтой ямартай ч золгоод байна. Монголын Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төв маань одоо өөрийн гэсэн ажлын байртай, хөрөнгө, санхүүгийн хувьд нэгэнт тогтворжжээ.

Тэрхүү 97 оныг 2004 онтой "золгуулсны" маань начир нь юунд байв аа? Монголын Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төвд багаар ажиллахад чанд бэлтгэгдсэн, ТББ-д ажиллах арга туршлагад сайтар суралцсан, хамгийн гол нь хүүхдийн төлөө гэх сэтгэлийг эргэлт буцалтгүй өвөртөлсөн, бас дээрээс нь аливаад нүд хурц, мэдрэмж соргог залуус гар нийлэн ажилладаг. Тэдгээр залуусын минь зорилго хүүхэд, өсвөр үеийнхний нийгмийн хэрэгцээнд тулгуурласан, өөр байгууллагуудын олж харахгүй байгаа,

тиймээс ч хүрч ажилладаггүй хөтөлбөрүүдийг санаачилж, зохион байгуулахад нэгдэж чадсанд байгаа юм.

Монгол орны ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд нэг ёсондоо байгууллагын маань нэрийн хуудас болоод байгаа "Миний паспорт" аяныг энд нэрлэе. Хамгийн товчоор тайлбарлахад, энэхүү аян нь хүүхэд, өсвөр үеийнхэнд нийгмийн амьдралд оролцох сэдлийг нь анх удаа гаргаж өгсөн учир зөвхөн төслийн хүрээнд хэрэгжүүлж байсан хүрээгээ тэлж, ганцхан жилийн дараа гэхэд Монгол Улсын Ерөнхий Сайдын ивээлд багтаж, үндэсний хэмжээнд өргөжсөн билээ. "Нийгмийн амьдралд оролцох сэдлийг анх удаа гаргаж өгсөн" гэсэн энэ хэсгийг би дахин онцолж байна. Энэ бол нийгэм, өсвөр үеийнхний хэрэгцээг соргогоор харж чадсаны илрэл болов уу.

"Миний сонин"-оо ч дурдах хэрэгтэй. Энэ бол мөн л өсвөр үеийнхний хэрэгцээг бодитой олж харсныхаа хүчинд үүсгэн байгуулсан, үйл ажиллагаагаа эхлээд хэдхэн сарын нүүр үзэж байгаа ч 12-16 насны хүүхдүүдийн унших дуртай, амьдрах арга ухааны мэдлэгийг цогцоор нь олгодог, уншсан л бол идэвхтэй амьдралд шургалан орох хүслийг бадрааж байгаа сонин. Уншигчдад өгч буй үр дүн нь илтэд мэдэгдэж байна. Тиймээс ч уншигч хүүхдүүд бидэнтэй өөрийн эрхгүй эргэх холбоо тогтоож байгаа нь бас нэг амжилт. Сонин маань дөнгөж хоёр дахь улирлынхаа захиалгаа авлаа. Хоёр мянга нэлээд хол гарсан захиалагчтай болсон дүн мэдээ гарчээ. Тэгэхээр төдий тооны хүүхэд ирээдүйд бие даан амьдрах ухаанд суралцаж байна гэсэн үг. Тэднээс гадна амьжиргааны доогуур түвшний 1500 өрхийн хүүхдэд "Миний сонин" үнэгүй хүрдэг. Харин шинэ улирлын захиалгаар дээрх тоо гучаар хорогдсон. Өөрөөр хэлбэл сониноо худалдан авч унших боломжгүй байсан 30 хүүхэд нэг улирлын турш үнэгүй уншсныхаа үр шимийг хүртэж, сонинд нийтлэгдсэний дагуу мөнгө олох аргад суралцаж, хэрэгжүүлснийхээ дүнд өөрийнхөө "олсон" мөнгөөр ийнхүү захиалсан байх юм.

Хүмүүс "Олон Улсын Боловсролын Үзэсгэлэн Яармаг" гэдэг нэрийг дуулахаараа манай байгууллагыг гэж таньдаг тухай хамт ажилладаг залуус маань ярьж байсан. Ортой л үг. Одоо харин шинээр хэрэгжүүлж эхлээд байгаа "Хүүхэд Ивээн Тэтгэх" хөтөлбөрийн маань нэрийг хүмүүс сонсмогцоо л Монголын Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төвийг санадаг болоосой гэж би хүсч байна. Хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг аливаа байгууллагын хөтөлбөрт хамрагдагч, үр шимийг нь хүртэгч

хүүхдүүд ихэвчлэн хагас, бүтэн өнчин, эсвэл хичээл сургуулиасаа завсардсан, тэнэмэл хүүхдүүд байдаг. Гэтэл сурч боловсрох, авьяас билгээ хөгжүүлэхийг чин сэтгэлээсээ хүсч, мөрөөддөг ч яагаад ч болдоггүй, тэрхүү "болдоггүй" шалтгаан нь эцэг эх, асран хамгаалагчдынх нь өрхийн орлогоос хамааралтай, хичээл сурлагадаа чармайлттай, авьяаслаг хүүхдүүдэд ямарваа тусламж, сэтгэлийн дэм, хөрөнгө оруулалт тэр бүр зориулагддаггүйг бид анхаарч харсан хэрэг. Хүүхдийн сайн сайхны төлөө эрхэм санаа өвөртлөн явдаг томчууд, тухайлбал, Дэлхийн банкны суурин төлөөлөгч Саха Меянтан, Японы ЭСЯ-ны зөвлөх Шимицу Таканори зэрэг гадаадын иргэд, Монгол улсын гавьяат багш Д.Банди, "Кредит Монгол" банк бус санхүүгийн байгууллага тэргүүтэй 12 байгууллага, хувь хүмүүс хөтөлбөрт хамрагдахаар сонгогдсон 30 хүүхдийг ивээлдээ авч, бүтэн жилийн сургалтын хэрэгцээг нь хангах, сургалт дамжаанд хамруулах, тэр ч бүү хэл их дээд сургуульд сургаж, мэргэжил боловсрол эзэмшүүлэн, цаашид өөрийн байгууллагадаа ажиллуулах хүртэл ивээн тэтгэлгийн хэлбэрийг хэрэгжүүлж эхлээд байгааг энэ дашрамд дурдахад таатай байна.

Өөрийн байгууллагынхаа онцлог талыг хэсэгхэн танилцуулмаар байна. Бид үйл ажиллагааныхаа хүрээнд "аминч" үзлийг хэзээ ч гаргадаггүй. Тайлбарлая. Аливаа оршин тогтнож байгаа байгууллага, аж ахуйн нэгж, тэр ч бүү хэл хувь хүмүүс ч хүртэл өөрийн дадлага туршлага, шинэ санаа, арга барилаа ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа нөгөөх этгээдүүддээ дэлгээд байдаггүй бол Монголын Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төв ийм бодлого баримталдаггүй. Харин ч өөрийн олж мэдсэн зүйлээсээ бусадтайгаа хуваалцахыг ямагт хичээдэг билээ. "Хүүхэд, залуучуудын солилцоо, сайн дур" хөтөлбөрийн маань үйл ажиллагаа үүнийг бэлхэнээ гэрчилнэ. Энэхүү хөтөлбөрт хүүхэд, залуучуудын төлөө үйл ажиллагаа явуулдаг гадаад дотоодын Төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд хамрагдаж, харилцан солилцож, ажлын арга барил, дадлага туршлагаасаа хуваалцдаг юм. Манай хөтөлбөрт мэргэжилтнээ хамруулснаар ажлын амжилт бүтээлд нь тодорхой үр дүн гардаг учраас л бидэнтэй холбоотой ажилладаг 40 гаруй байгууллага энэхүү хамтын ажиллагаагаа үргэлжлүүлдэг. Хамтрагч байгууллагуудын маань хүрээ цаашид улам бүр тэлнэ гэдэгт би итгэлтэй байдаг. Дээрх хөтөлбөрөөс гадна "Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн зорилгоор ашиглахын эсрэг олон улсын сүлжээ" буюу "ЕСРАТ"-д нэгдэх үндэсний сүлжээг санаачлан

байгуулж, энэ чиглэлээр ажилладаг Төрийн болон Төрийн бус 20 гаруй байгууллагыг нэгтгэн, үндэсний хэмжээнд ажиллах сүлжээний дүрэм, ажлын төлөвлөгөө боловсруулах, олон улсын сүлжээнд нэгдэх бэлтгэл хангах зэрэг ажлуудыг амжилттай хийж байна.

Би 13 жил энэ салбарт ажиллаж, хөдөлмөрлөж байна. Энэ хугацаанд хүүхдийн болон өсвөр үеийнхний оролцоотой Төрийн бус хорь гаруй байгууллага үүсэн байгуулагдаж байв. Гэвч өнөөдөр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь Монголын Скаутын Холбоо, Эмэгтэй скаут, Идэрчүүдийн Холбоо, Залуучууд-Улаан Загалмай, Нэг Ертөнц зэрэг хүүхдийн оролцооны цөөн хэдэн Төрийн бус байгууллага. Монгол орны хүүхэд, өсвөр үеийнхний 10 хүрэхгүй хувь нь л дээрх цөөн хэдэн байгууллагын гишүүнчлэлд хамрагддаг нь дэндүү хангалтгүй үзүүлэлт. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл эрхэлдэг ажил төрлийнхөө хажуугаар, сайн дураараа хүүхдийн байгууллагын үйл хэрэгт хичээл зүтгэлээ өгчих сэтгэлтэй хүн ховордож. Бас нэг шалтгаан гэвэл, цаад байгууллага нь гишүүдийнхээ төлөө үйл ажиллагаа явуулъя гэхэд "хөрөнгө, мөнгө" гэдэг том бэрхшээл хана болон босоод ирдэг. Ийм л учраас хүүхэд, өсвөр үеийнхний оролцоотой ТББ болон хүүхдийн төлөө ажилладаг ТББ-уудын ихэнх нь үйл ажиллагаагаа жигд явуулж чадахгүйд хүрдэг. "Хүүхдийн Төлөө" гэдэг нэрээрээ бусад байгуулагатайгаа ижилсдэгийн хувьд энэ "кризис" үеийг халахын тулд "Төрийн бус байгууллагын чадавхи нэмэгдүүлэх" гэсэн бие даасан хөтөлбөрийг 2001 оноос хэрэгжүүлэн, хамтлаг хөдөлгөөнүүдийн идэвхтэн сонгуультнууд, төрийн бус байгууллагын удирдагчдад зориулсан олон удаагийн цуврал сургалтуудыг зохион байгуулж, хоёр төрлийн гарын авлага /"Та бүхэн эвлэлдэн нэгдэхийг хүсвэл", "Төрийн бус байгууллагын удирдагчдад зориулсан 100 асуулт хариулт"/ боловсруулж тус бүрийг 1000 хувиар хэвлэн тараасан юм. Энэхүү ажиллагааны үргэлжлэл болгон "Хүүхэд залуучуудын Төрийн бус байгууллагууд төр засагтай түншлэн ажиллах нь" гэсэн зөвлөмжийг мэргэжилтнүүдийн оролцоотойгоор боловсруулан хүүхэд залуучуудын асуудал хариуцсан Их хурлын холбогдох гишүүд, Төрийн яам, газруудын сайд, дарга нарт хүргүүлэн саналыг нь тусган эцэслэн боловсруулж, НХХЯам болон хүүхэд, өсвөр үеийнхний оролцоотой болон хүүхдийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг ТББ-ууд хамтран "Түншлэлийн холбоо" байгуулах ажлыг эхлээд, амжилтад хүрэхэд тун ойртоод байна. Уг түншлэлийн холбоог байгуулахын гол зорилго

нь хүүхэд, залуучуудын ТББ-аар төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх, уг арга хэмжээг хийж гүйцэтгэх санхүүгийн дэмжлэгийг төрөөс олгох, жижиг төслийн саналыг дэмжих хэлбэрээр явуулахад оршиж байгаа юм. Өөрөөр хэлбэл хүүхдээр овоглосон байгууллагуудын хувьд хонгилын үзүүрт гэрэл үзэгдэж эхэллээ.

Хувь, хувьсгалын ажлаар гадаадын улс орноор явах болгондоо миний хамгийн их сонирхож, судалдаг зүйл бол тухайн орны Төрийн бус байгууллагын арга туршлага байдаг. Арга туршлага дотроо мэдээж санхүүжилт гэдэг "хүндрэлтэй" асуудлыг хэрхэн шийддэг тухай нь. Ер нь ихэнх Төрийн бус байгууллага нь өөрийн гэсэн санхүүжилт олох алба, эсвэл дэргэдээ менежмент компанитай байдаг. Санхүүжилт олох салбар нь хандив цуглуулах, сугалаа лотерей явуулах, танилцуулга, үзэсгэлэн зохион байгуулах зэрэг олон замаар мөнгөн хуримтлал үүсгэдэг. Тэгээд үүссэн мөнгөн хуримтлалаа зорилгот үйл ажиллагаандаа зарцуулдаг байх юм. "Дэлхийн Скаутын Холбоо", "YWCA", "YMCA" зэрэг үйл ажиллагаа, нэр хүндээрээ олон улсад танигдсан гаднын орны Төрийн бус байгууллагууд менежмент компани санаачилж, хууль горимынх нь дагуу байгуулаад, ямар нэгэн төлбөртэй үйлчилгээ явуулдаг. Өөрөөр хэлбэл, тэрхүү менежмент компани нь зочид буудал, зуслангийн үйл ажиллагаа эрхэлж, олсон орлогоороо гишүүдийнхээ төлөө хэрэгжүүлэх арга хэмжээгээ санхүүжүүлдэг. Ганц зочид буудал, зуслан ч бус, хямд төсөр үйлчилгээ үзүүлэх түргэн хоолны газар, хуучин хувцасны дэлгүүр гээд Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн түшиц болдог газар барууны оронд хаа сайгүй таардаг. Эрхэм Та ч гэсэн хаа нэгэн улсад зорчин явахдаа тэднээр үйлчлүүлэн, цаана нь орших, үүсгэн байгуулагч Төрийн бус байгууллагынх нь санхүүжилтэд хувь нэмэр оруулсан л байж таарна. Өөр нэг арга нь, дэргэдээ сан байгуулах. Тэрхүү сан нь мөнгө хуримтлуулах үйл ажиллагаа явуулж, мөнгөн хуримтлалаа банкинд байрлуулж, хүүгээр нь Төрийн бус байгууллагынхаа санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэдэг. Эдгээр аргууд нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдөж, бүр санхүүжилт олох мэргэжилтэн бэлтгэдэг механизмтай ч болсон байдаг аж. Монголчууд "Сайныг нь аваад, саарыг нь хаях" гэдэг үгийг хүүхдээ хүмүүжүүлэхдээ их хэрэглэдэг. Манай байгууллага ч мөн адил үйл ажиллагаандаа ахиц дэвшил олж, өөрсдийгөө "хүмүүжүүлэх"-ийн тулд барууны дээрх туршлагыг нэвтрүүлэхээр болж, удирдах зөвлөлөөрөө хэлэлцээд компани санаачлан, мөн л холбогдох

хууль горимынх нь дагуу байгуулсан. Байгуулахдаа бусдын л адил банкнаас зээл авсан. Тэр зээлсэн мөнгө маань байгуулж буй компанийн голлон эрхлэх "Модерн Номадс" рестораны үйл ажиллагаанд зарцуулагдсан. Одоогоор зээл төлөлтийнхөө хугацаанд яваа. Ийнхүү зориглож байгуулсан ресторан маань МХЗХТ-ийн хувьд бусдын гар харахгүй байх гол арга маань билээ. Тун удахгүй өр төлөгдөж дуусна. Тэр цагт МХЗХТ-ийн санаачилсан ресторан Монгол орныхоо хүүхэд, өсвөр үеийнхний төлөө явуулж байгаа болон явуулах үйл ажиллагаануудын маань санхүүгийн гол түшиц тулгуур болох учиртай билээ.

Туршлага судалсан байгууллагынхаа жишгээр бид өөрийн гэсэн санхүүжилт олох албыг ч байгуулсан. Энэ албын санаачилсан ажлын анхны үр шимийг одоо "Хүүхэд Ивээн Тэтгэх" хөтөлбөрийн хүүхдүүд маань хүртэж байгаа. Бүр тодруулбал, дээр дурдсан гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсээс хуримтлагдсан 2000 ам.доллар тэдгээр 30 хүүхдийн бүтэн жилийн сургалтын хэрэгцээ, төлбөр хураамжинд зарцуулагдаж эхлээд байгаа билээ.

Донор байгууллагууд биднийг насан туршид маань тэтгэхгүй нь ойлгомжтой. Өөрсдөө хөл дээрээ тогтох, бүр эгцхэн хэлэхэд, мөнгө олох маш олон арга бидэнд байна. Соргоогоор харж, сэргэгээр хэрэгжүүлж, ухаантай ажиллацгаая.